

БАТЛАВ
"АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ"
ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ

Б.ГҮРСОРОНЗОН

2025 оны 06-р сарын 23-ны өдөр
хот

БАТЛАВ
"ӨШИГ" ХХК ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ
М.ОТГОНБАЯР

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

№ 0726/62

Улаанбаатар

Нэг талаас "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ыг төлөөлж, Захиргаа, сургалт, хүний нөөцийн хэлтсийн дарга Б.Баатарцол /цаашид "Захиалагч" гэх/, нөгөө талаас "Өшиг" ХХК-ыг төлөөлж, Ерөнхий редактор Т.Хулантахь /цаашид "Гүйцэтгэгч" гэх/, /цаашид хамтад нь "Талууд" гэх/ нар нь доор дурдсан нөхцөлөөр харилцан тохиролцож, энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын хийж хэрэгжүүлж буй үйл ажиллагаа болон цаг үеийн мэдээ, мэдээллийг www.isee.mn вэб хуудсаар олон нийтэд мэдээллэх, тээврийн үйл ажиллагаатай холбогдон гарсан тушаал шийдвэрийг цаг алдалгүй танилцуулах, захиалагч гэрээгээр тохирсон төлбөрийг төлөх, үүнтэй холбогдон гарах талуудын эрх, үүргийг тодорхойлоход энэ гэрээний гол зорилго оршино.
- 1.2 "Мэдээ мэдээлэл" гэдэг нь мэдээ, сурвалжилга, ярилцлага, нийтлэл зэрэг сэтгүүлзүйн бичлэгийн төрөл зүйлүүдээр бэлтгэсэн мэдээллийг хэлнэ.
- 1.3 Гэрээний хугацаа 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийг дуусталх хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

Хоёр. Төлбөр тооцоо

- 2.1 Гэрээний нийт үнийн дүн 6.000.000 /зургаан сая/ төгрөг байна.
- 2.2 Гэрээний төлбөрийн үнийн дүнд НӨАТ багтсан болно.
- 2.3 Гэрээ байгуулсны дараа Гүйцэтгэгчийн Голомт банкны MN11001500 1415126197 тоот дансанд, нэхэмжлэхийн дагуу ажлын 5 (тав) хоногийн дотор нийт үнийн дүнгийн 70 хувийг урьдчилгаа хэлбэрээр шилжүүлнэ. Үлдэгдэл 30 хувийг гүйцэтгэлийн тайлан, гэрээ дүгнэсэн акт болон бусад холбогдох баримт бичигт үндэслэн, нэхэмжлэхийн дагуу төлнө.

Гурав. Захиалагчийн эрх, үүрэг

3.1 Захиалагч дараах эрхтэй:

- 3.1.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг гүйцэтгэгчээс шаардах

- 3.1.2 Гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шаардах
- 3.1.3 Мэдээ сурвалжилгын талаар мэргэжлийн зөвлөгөө, мэдээлэл, санал өгөх
- 3.1.4 Байршуулсан мэдээ сурвалжилга, ярилцлага, нийтлэлийг хэвлэмэл болон линкээр хуулбарлаж авах
- 3.1.5 Энэхүү гэрээнд заасан сувгуудаар мэдээ мэдээллийг бүрэн дамжуулахыг шаардах
- 3.1.6 Цаг үетэй холбоотой шуурхай мэдээллийг цаг алдалгүй мэдээлэхийг шаардах
- 3.1.7 Захиалагчийн үйл ажиллагаатай холбогдолтой бодит эх сурвалжгүй мэдээлэл гаргахгүй байх
- 3.1.8 Шаардлагатай тохиолдолд Гүйцэтгэгчээр мэдээ мэдээллийг бэлтгүүлэх, өөрчлүүлэх, видео бичлэг хийлгүүлэх
- 3.1.9 Хуульд заасан бусад эрх

3.2 Захиалагч дараах үүрэгтэй:

- 3.2.1 Мэдээ мэдээллийн хуульд нийцсэн, үнэн зөв, бодит байдлыг хариуцах
- 3.2.2 Бэлэн мэдээ, сурвалжилга, ярилцлага, нийтлэл цацах тохиолдолд 1-3 хоногийн өмнө захиалгаа өгсөн байна.
- 3.2.3 Өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас гүйцэтгэгчид учирсан хохирлыг нөхөн төлөх
- 3.2.4 Гэрээний биелэлтийг хангах зорилгоор өөрийн ажилтнуудаас гүйцэтгэгчтэй харилцах ажилтнуудыг томилох
- 3.2.5 Өөрийн мэдээ мэдээлэл, нэвтрүүлэг, зар сурталчилгаа нийтлэгдэхээс 1-3 хоногийн өмнө мэдэгдэх
- 3.2.6 Хуульд заасан бусад үүрэг.

Дөрөв. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

4.1 Гүйцэтгэгч дараах эрхтэй:

- 4.1.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг захиалагчаас шаардах
- 4.1.2 Захиалагч нь хууль тогтоомжийн дагуу бүтээх болон түгээхийг хориглосон мэдээллийн захиалга өгсөн тохиолдолд захиалгыг хүлээн авахаас татгалзах
- 4.1.3 Шаардлагатай тохиолдолд мэдээ, мэдээллийн үнэн зөв болохыг нотлох баримтыг захиалагчаас шаардах
- 4.1.4 Хуульд заасан бусад эрх

4.2 Гүйцэтгэгч дараах үүрэгтэй:

- 4.2.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ биечлэн гүйцэтгэх, үүргээ бусад этгээдэд /Гуравдагч этгээд/ шилжүүлэхгүй байх
- 4.2.2 Хүлээн авсан бэлэн мэдээ, мэдээллийг өөрчлөлт оруулахгүйгээр, албан бичгээр ирүүлсэн хүсэлт болон энэхүү гэрээнд заагдсан сувгуудаар тоон хязгаар тавихгүй бүрэн байршуулах

- 4.2.3 Захиалагчийн зүгээс цаг үеийн байдалтай холбоотой шуурхай мэдээ өгсөн даруйд цаг алдалгүй мэдээлэх
- 4.2.4 Захиалагчийн үйл ажиллагаатай холбогдолтой бодит эх сурвалжгүй мэдээллийг олон нийтэд цацахгүй бөгөөд захиалагч талын итгэмжлэгдсэн төлөөлөгчид заавал мэдэгдэж, тухайн мэдээллийн үнэн зөвийг магадална.
- 4.2.5 Мэдээ мэдээлэл, ярилцлага, нийтлэл, зар сурталчилгааны шинж чанартай материалыг гэрээнд заасан нөхцөл, журмыг зөрчсөн буюу өгсөн эх загвараас өөрөөр, алдаатай мэдээлэл гүйцэтгэгчээс хамаарах болон үл хамаарах /Гэмтэл болон бусад/ шалтгаанаар дутуу нийтлэгдээгүй тохиолдол бүрт нөхөн гаргах
- 4.2.6 Захиалагч талд энэхүү гэрээний хүрээнд хийгдсэн ажил үйлчилгээг улирал тутамд гүйцэтгэлийг тайлагнах
- 4.2.7 Захиалагчийн арга хэмжээ, мэдээ мэдээллийг сурталчлах, шуурхай мэдээ мэдээллийг цаг алдалгүй солилцож, байнгын харилцах албан тушаалтныг томилох
- 4.2.8 Хуульд заасан бусад үүрэг

Тав. Бусад зүйлс

- 5.1 Энэхүү гэрээг 2 хувь үйлдэн, талууд гарын үсэг зурж, баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох бөгөөд хувиуд хуулийн хувьд адил хүчинтэй байна. Гэрээний 1 хувийг захиалагч, 1 хувийг гүйцэтгэгч тус тус хадгална.
- 5.2 Талууд өөрийн буруутай үйлдлийн улмаас нөгөө талдаа хохирол учруулсан бол хохирлыг бүрэн хариуцна.
- 5.3 Талууд энэхүү гэрээг байгуулсан тухай болон гэрээг хэрэгжүүлэх явцад шууд болон шууд бус замаар олж мэдсэн байгууллага, хувийн нууцад хамаарах аливаа мэдээ, мэдээллийг бусдад бичгээр болон аман хэлбэрээр задруулахгүй байх үүргийг хүлээнэ.
- 5.4 Гүйцэтгэгч гэрээний үүргээ бусдад бүрэн буюу хэсэгчлэн шилжүүлэхгүй.
- 5.5 Энэ гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг Иргэний хууль, холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.
- 5.6 Талууд гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах хүсэлт гаргавал албан бичгээр 14 хоногийн өмнө мэдэгдэнэ. Аль нэг тал гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд гэрээг нэг талын санаачилгаар шууд цуцлах эрхтэй.
- 5.7 Давагдашгүй хүчин зүйл болон бусад нөхцөл байдлаас шалтгаалан гэрээнд нэмэлт өөрчлөлтүүдийг зөвхөн албан бичгээр хийх бөгөөд эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр гэж үзэх ба энэ нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 5.8 Уг гэрээтэй холбогдон гарч болох аливаа маргаан, үл ойлголцох байдлыг талууд харилцан итгэлцэл бие биеэ хүндэтгэх замаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд ингэж чадаагүй нөхцөлд шүүхийн журмаар шийдвэрлэнэ. Шүүхийн шийдвэр эцсийн шийдвэр байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Захиалагчийг төлөөлж:

Захиргаа, сургалт, хүний нөөцийн
хэлтсийн дарга:

..... Б.Баатарцол

Санхүү, эдийн засгийн хэлтсийн
дарга:

..... Р.Баасандорж

ХАЯГ:

Улаанбаатар хот, Хан- уул дүүрэг,
3-р хороо, Ариг банкны байр
Автотээврийн үндэсний төв

Мэйл хаяг: info@transdep.mn

Утас: 70070012, 1900-1234 .
РД: 5324165

Гүйцэтгэгчийг төлөөлж:

"Өшиг" ХХК -ийн
Ерөнхий редактор



Т.Хулантахы/

ХАЯГ:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
9-р хороо, "Шинэ дэлхий" ТВ байр,
8 давхарт, 808 тоот

Мэйл хаяг: isee.mn@gmail.com

Утас: 76002080, 88024093
РД: 6401376

ГЭРЭЭ ДҮГНЭСЭН АКТ

2025 оны 12-р сарын 20-ны өдөр

№АГГ25/32

Улаанбаатар хот

"Өшиг" ХХК, www.isee.mn вэб сайт түүнийг төлөөлж захирал М.Отгонбаяр /цаашид "Гүйцэтгэгч" гэх/ болон "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ түүнийг төлөөлж Захиргаа, сургалт, хүний нөөцийн хэлтсийн дарга Б.Баатарцол /цаашид "Захиалагч" гэх/, нар нь 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдөр № АГГ25/32 дугаар "Ажил гүйцэтгэх гэрээ" байгуулсан.

- Гэрээний хугацаанд гэрээнд заагдсан үүргээ биелүүлж захиалагчаас нийлүүлсэн мэдээ мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлж, мэдээ мэдээллийг иргэд олон нийтэд хүргэж ажиллав.

Захиалагч гэрээ баталгаажсаны дараа нийт үнийн дүнгийн 70 хувь 4.200.000 /дөрвөн сая хоёр зуун мянга/ төгрөгийн төлбөрийг гүйцэтгэгчийн Голомт банкны MN11001500 1415126197 дугаарын дансанд шилжүүлсэн.

Гүйцэтгэгч нь гэрээнд заасан ажлыг тохиролцсон хугацаандаа бүрэн хийж гүйцэтгэсэн болно.

Гэрээнд тусгасны дагуу гүйцэтгэгчийн ажлын үлдэгдэл төлбөрийн 30 хувь болох /нэг сая найман зуун мянга/ төгрөгийн төлбөрийг гүйцэтгэгчийн Голомт банкны MN11001500 1415126197 дугаарын дансанд шилжүүлнэ.

Гэрээний нийт үнийн дүн 6.000.000 /зургаан сая/ төгрөг байна.

Гэрээний хугацаанд гарсан зөрчилгүй, гэрээнд оролцогчдын дунд ямар нэгэн маргаангүй, талууд гэрээтэй холбоотой нэмэлт үүрэг хүлээгээгүй тул харилцан тохиролцон гэрээг дуусгавар болгон дүгнэж акт үйлдэв.

ГЭРЭЭГ ДҮГНЭСЭН:

Захиалагчийг төлөөлж:

Гүйцэтгэгчийг төлөөлж:

"АВТО ТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ
ТӨВ" ТӨҮГ

"ӨШИГ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ

ЗАХИРГАА СУРГАЛТ ХҮНИЙ
НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН ДАРГА



Б.БААТАРЦОЛ



М.ОТГОНБАЯР